



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШТАР  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ширнэнбаньдын АДЬШАА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-61-40, Факс: 32-70-16  
E-mail: adishaash@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023. 12. 24 № ЧЧХ-03/10801

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг санаачлан боловсруулж, өргөн мэдүүлж байна.

Уг хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 29 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ш.АДЬШАА

Г.ЗАНДАНШТАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ц.ДАВААСҮРЭН

Д.ТОГТОХСҮРЭН

• 001155



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Ширнэнбаньдын АДЬШАА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
 Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
 Утас: 26-61-40, Факс: 32-70-16  
 E-mail: adishaash@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023. 11. 24 № ЧИЯ-03/9493

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
 тов тогтоолгох тухай

Г МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
 ТАМГЫН ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД  
 ДАРГА М.ҮНЭНБАТ ТАНАА

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянаж үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт 26 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
 ГИШҮҮН



Ш.АДЬШАА

001030



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ширнэнбаньдын АДЬШАА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-61-40, Факс: 32-70-16  
E-mail: adishaash@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023.10.02 № ЧИХ-03/7617

таний \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Хуулийн төсөлд санал  
авах тухай Г

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар хүргүүлж байна.

Иймд дээрх хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэгт заасны дагуу саналаа ирүүлнэ үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгааг хавсаргав.

Хавсралт хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Ш.АДЬШАА



000767

БАТЛАВ.  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ш.АДЬШАА

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

TUS3784 9023051363 9087164

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

**1.1 Хууль зүйн үндэслэл**

Монгол Улс 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр ашигт малтмал, уул уурхайн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд үйл ажиллагаа эрхлэх боломж бурдсан бөгөөд тус салбарт хөрөнгө оруулалт татах төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 1994, 1997 онд тус тус Ашигт малтмалын тухай хуулийг баталсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадгаар зүйлд зааснаар “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна; Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж заасан нь ашигт малтмалын өмчлөгч нь төр байх ба энэ утгаараа тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий субъект нь Төрийн захиргааны байгууллага байхыг хуульчилсан байна. Мөн Монгол Улсын 2006 оны Ашигт Малтмалын тухай хуулийн тавдугаар зүйлд “Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн” бөгөөд “Төр өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй” гэж заасан байна.

Ийнхүү шилжилтийн үед тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны эрх зүйн үндэс тавигдсан гэж үзэж болох юм.

Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бурд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.

Шийдвэр гаргах түвшинд орон нутгийн байгууллага, иргэдийн бодитой оролцоог хангах замаар харилцан итгэлцлийн тогтолцоог бий болгох асуудал сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд уул уурхайн салбарын засаглалын тулгамдсан асуудал хэвээр байна. Хаалттай засаглал, хариуцлагагүй уул уурхай, харилцааны үл ойлголцол нь төсөл, хөтөлбөрийг үгүйсгэх хандлагыг иргэдийн дунд бий болгож байгааг бүх талууд хүлээн зөвшөөрдөг. Иймд дээрх асуудлыг оновчтой шийдвэрлэхгүйгээр тогтвортой хөгжил, салбарын өсөлт хөгжлийг хангах боломжгүй юм.

Мэдэх эрхийн хүрээнд ашиглалын тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг иргэдийн мэдэх эрхийн хүрээнд нэмэгдүүлэх шаардлагатай байна.

## 1.2 Практик шаардлага

Уул уурхайн үйл ажиллагаа нь алслагдсан хөдөө орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зам тээвэр, ус ба цахилгаан зэрэг дэд бүтэц хөгжүүлэх, уул уурхайн ашиг орлого, татварын орлогыг дахин хуваарилах замаар улсын төсвийн хуваарилалт болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын төслийд хэрэгжүүлэх зэрэг олон эерэг үр нөлөөг орон нутагт авчрах боломжтой. Гэвч уул уурхайн үйл ажиллагаа нь иргэдийн нүүлгэн шилжүүлэлт, амьжиргаа ба соёлын өөрчлөлтүүд, замын хөдөлгөөн, тоосжилт, дуу чимээ зэрэг эрүүл мэнд болон аюулгүй байдлын нөлөөллүүд, орон нутгийн хүн амын өсөлтөөс үүдэн нийгмийн дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээнд нэмэлт ачаалал үүсэх зэрэг сөрөг үр дагавар үүсгэх боломжтой.

"Хариуцлагатай тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэдэг нь уул уурхайн үйл ажиллагаа явагдах орон нутгийн иргэдийн эрх ашигийг хүндэтгэх, байгаль орчинд хохирол, нөлөө багатай үйл ажиллагаа эрхлэх, нөхөн сэргээлт-хаалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх, цаг тухайдаа бүрэн хэмжээгээр ашигт малтмалын нөөцийн төлбөр болон холбогдох бусад татвараа төлөх гэсэн ухагдахуун байдаг. Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх асуудал нь олон улсын уул уурхайн салбарын гол зорилго бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих ерөнхий шаардлагыг шалгуур үзүүлэлтийн "хүлээн зөвшөөрөгдсөн байдал" үзүүлэлтээр дүгнэхэд хангахгүй байна. Иймд хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл, ашиглалтын тусгай зөвшөөр асуудал нь олон улсын уул уурхайн салбарын гол зорилго бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагад өмчлөгч, эзэмшигч, ашиглагчаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах, нутгийн иргэдийн эрх ашигийг хүндэтгэх, байгаль орчинд хохирол багатай үйл ажиллагаа явуулах нь зүйтэй учраас "Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль"-ийн төслийг боловсруулав.

Ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэм болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг учраас Монгол Улсын хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлж ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх зохицуулалт үгүйлэгдэж байна.

### Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь З зүйлтэй байхаар тусгагдсан ба 1 дүгээр зүйлд, Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.4. тухайн талбай нь өмчлөгч, эзэмшигч, ашиглагчаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байх. Гэж нэмэх бол, 2 дугаар зүйлд, "Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.9. Эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ." гэж нэмэх, 3 дугаар зүйлд, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалтыг "42.3. .... ажиллуулж болно" гэснийг "ажиллуулна." гэж өөрчлөхөөр тусгана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуульд санал болгож буй нэмэлт, өөрчлөлт оруулснаар дараах нийтлэг дутаглууд арилна. Үүнд:

- Ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах гэж буй талбай нь өмчлөгч, эзэмшигч, ашиглагч болон нутгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах гэж буй талаар иргэд мэдээллээр хангагдах эрх зүйн үндэс бий болно.
- Орон нутгийн иргэдийн эрх ашгийг хүндэтгэх, байгаль орчин, эрүүл мэндэд хохирол, нөлөө багатай үйл ажиллагаа эрхлэх, нөхөн сэргээлт төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх боломж бүрдэнэ.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүрэн хэрэгжих боломж бүрдэнэ.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиуд, Улсын Их Хурлын холбогдох тогтоолуудтай нийцсэн болно.

## **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадгаар зүйлд зааснаар “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна; Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж заасан нь ашигт малтмалын өмчлөгч нь төр байх ба энэ утгаараа тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий субъект нь Төрийн захиргааны байгууллага байхыг хуульчилсан байна. Мөн Монгол Улсын 2006 оны Ашигт Малтмалын тухай хуулийн тавдугаар зүйлд “Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн” бөгөөд “Төр өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй” гэж заасан байна.

Уул уурхайн үйл ажиллагаа нь алслагдсан хөдөө орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зам тээвэр, ус ба цахилгаан зэрэг дэд бүтэц хөгжүүлэх, уул уурхайн ашиг орлого, татварын орлогыг дахин хуваарилах замаар улсын төсвийн хуваарилалт болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын төслүүд хэрэгжүүлэх зэрэг олон эерэг үр нөлөөг орон нутагт авчрах боломжтой. Гэвч уул уурхайн үйл ажиллагаа нь иргэдийн нүүлгэн шилжүүлэлт, амьжиргаа ба соёлын өөрчлөлтүүд, замын хөдөлгөөн, тоосжилт, дуу чимээ зэрэг эрүүл мэнд болон аюулгүй байдлын нөлөөллүүд, орон нутгийн хүн амын өсөлтөөс үүдэн нийгмийн дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээнд нэмэлт ачаалал үүсэх зэрэг сөрөг үр дагавар үүсгэх боломжтой.

“Хариуцлагатай тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэдэг нь уул уурхайн үйл ажиллагаа явагдах орон нутгийн иргэдийн эрх ашигийг хүндэтгэх, байгаль орчинд хохирол, нөлөө багатай үйл ажиллагаа эрхлэх, нөхөн сэргээлт-хаалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх, цаг тухайдаа бүрэн хэмжээгээр ашигт малтмалын нөөцийн төлбөр болон холбогдох бусад татвараа төлөх гэсэн ухагдахуун байдал. Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх асуудал нь олон улсын уул уурхайн салбарын гол зорилго бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих ерөнхий шаардлагыг шалгуур үзүүлэлтийн “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” үзүүлэлтээр дүгнэхэд хангахгүй байна. Иймд хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл, ашиглалтын тусгай зөвшөөр асуудал нь олон улсын уул уурхайн салбарын гол зорилго бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагад өмчлөгч, эзэмшигч, ашиглагчаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах, нутгийн иргэдийн эрх ашигийг хүндэтгэх, байгаль орчинд хохирол багатай үйл ажиллагаа явуулах нь зүйтэй учраас “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль”-ийн төслийг боловсруулав.

## **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсрууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадгаар зүйлд зааснаар “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна; Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж заасан нь ашигт малтмалын өмчлөгч нь төр байх ба энэ утгаараа тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий субъект нь Төрийн захиргааны байгууллага байхыг хуульчилсан байна. Мөн Монгол Улсын 2006 оны Ашигт Малтмалын тухай хуулийн тавдугаар зүйлд “Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн” бөгөөд “Төр өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй” гэж заасан байна.

Оролцогч талуудын харилцан итгэлцэлд суурилсан хариуцлагатай, тогтвортой уул уурхайг хөгжүүлэхэд олон нийтийн бодитой оролцоог хангах, эрх, ашиг сонирхлыг нь хөндөх асуудлаар тэднээс чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөл авах нь чухал ач холбогдолтой.

Шийдвэр гаргах түвшинд орон нутгийн байгууллага, иргэдийн бодитой оролцоог хангах замаар харилцан итгэлцлийн тогтолцоог бий болгох асуудал сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд уул уурхайн салбарын засаглалын тулгамдсан асуудал хэвээр байна. Хаалттай засаглал, хариуцлагагүй уул уурхай, харилцааны үл ойлголцол нь төсөл, хөтөлбөрийг үгүйсгэх хандлагыг иргэдийн дунд бий болгож байгааг бүх талууд хүлээн зөвшөөрдөг. Иймд дээрх асуудлыг оновчтой шийдвэрлэхгүйгээр тогтвортой хөгжил, салбарын өсөлт хөгжлийг хангах боломжгүй юм.

НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо уул уурхайн төслүүдийн малчин иргэдийн хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөө, тэр дундаа малчдын ашиглаж дадсан газар нутагт Засгийн газар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход малчдын чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрлийг авдаггүй талаар санаа зовниж байгаагаа илэрхийлээд Монгол улсад дараах зөвлөмжийг өгсөн. Эдгээрт, (а) ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохоосоо өмнө хүний эрхийн болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх; (б) үнэлгээний явцад тухайн төслийн нөлөөлж болох бүхий л сонирхогч этгээдүүдийн идэвхтэй оролцоог хангах; (в) малчдын эрхэд нөлөөлж ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохоос өмнө тэдэнтэй өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулах; (г) малчдад хүртээмжтэй, зардал багатай, үр дүнтэй гомдол гаргах механизмыг бий болгох; (д) тэдэнд зохистой нөхөн төлбөр олгох явдлыг хангах зэрэг хамаарна.

Гэвч эрдэс баялгийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийг эрчимжүүлэх бодлого, арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлэхдээ ашигт малтмалын үйл ажиллагааны улмаас эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн, нөлөөлөлд

өртсөн иргэд, олон нийтийн бодитой оролцоог сулруулж, тэдний шүүмжлэлийг дарах оролдлого хийж байгаад иргэний нийгмийн байгууллагууд болон иргэд санаа зовниж байгаагаа илэрхийлсээр байна.

Монгол Улсад эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэдтэй бодитоор зөвшилцөх, тэднээс чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөл авах олсад нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоог бүрдүүлэхэд бодитой ахиц гарахгүй байгаа бөгөөд зарим тохиолдолд ухралт ажиглагдаж байна. Ийнхүү иргэдтэй бодитоор зөвшилцөх зохицуулалт шаарлагатай байгаа тул уг хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөл, танилцуулгад олон нийтээс санал авахаар dparliament вэб сайтад 2023 оны 10 дугаар сарын 15-аас 11 дүгээр сарын 13-ны хугацаанд байршуулан нээлттэй хэлэлцүүлсэн.

--- oOo ---

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгүй:

1/ 24 дүгээр зүйлийн 24.4.4. дэх заалт “24.4.4. тухайн талбай нь өмчлөгч, эзэмшигч, ашиглагчаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байх.”

2/ 24 дүгээр зүйлийн 24.6, 24.7, дахь хэсэг:

“24.6. тухайн тайлбай хамаарах хэсгийг иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж зөвшөөрөл авсан байх, уг зөвшөөрөл сонгон шалгаруулалтын үндэслэл болно.”

“24.7. тухайн талбай нь хамаарч буй сум, дүүргийн иргэдийн хурлаас зөвшөөрөл авсан байх.”

3/ 25 дугаар зүйлийн “25.1.9. Эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ.”

**2 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “ажиллуулж болно” гэснийг “ажиллуулна.” гэж өөрчилсүгүй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

### **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Эрдэс баялгийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийг эрчимжүүлэх бодлого, арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлэхдээ ашигт малтмалын үйл ажиллагааны улмаас эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн, нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийтийн бодитой оролцоог сулруулж, тэдний шүүмжлэлийг дарах оролдлого хийж байгаад иргэний нийгмийн байгууллагууд болон иргэд санаа зовниж байгаагаа илэрхийлсээр байна.

Монгол Улсад эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэдтэй бодитоор зөвшилцөх, тэднээс чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөл авах олон улсад нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоог бүрдүүлэхэд бодитой ахиц гарагчийг байгаа бөгөөд зарим тохиолдолд ухралт ажиглагдаж байна.

Ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэм болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг учраас Монгол Улсын хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлж ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх зохицуулалт үгүйлэгдэж байна.

### **УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

#### **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаагийн санаачлан боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадгаар зүйлд зааснаар “Монгол Улсад газар, түүний хэвлэй, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна; Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлэй, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн”гэж заасны дагуу, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барив.

Хуулийн төслийг боловсруулсан зорилго нь Монгол Улсад эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэдтэй бодитоор зөвшилцөх, тэднээс чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөл авах олон улсад нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН**

Монгол Улс 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр ашигт малтмал, уул уурхайн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд үйл ажиллагаа эрхлэх боломж бүрдсэн бөгөөд тус салбарт хөрөнгө оруулалт татах төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 1994, 1997 онд тус тус Ашигт малтмалын тухай хуулийг баталсан байдаг.

Уул уурхайн улмаас орон нутгийн иргэд, ялангуяа малчин иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрх өргөн хүрээнд ноцтой зөрчигдөж байгааг онцгойлон анхаарч, малчдын уламжлалт аж амьдралыг хадгалахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх шаардлагатай болохыг үндэсний болон олон улсын хүний эрхийн тайлан, зөвлөмжид онцолсон хэвээр байна.

Шийдвэр гаргахаас өмнө төслийн нөлөөлөлд өртсөн иргэдийг холбогдох мэдээллээр хангасны үндсэн дээр зөвлөлдөж, санал шүүмжээ чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Хуульд санал болгож буй нэмэлт, өөрчлөлт оруулснаар дараах нийтлэг дутаглууд арилна. Үүнд:

- Ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах гэж буй талбай нь өмчлөгч, эзэмшигч, ашиглагч болон нутгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах гэж буй талаар иргэд мэдээллээр хангагдах эрх зүйн үндэс бий болно.
- Орон нутгийн иргэдийн эрх ашгийг хүндэтгэх, байгаль орчин, эрүүл мэндэд хохирол, нөлөө багатай үйл ажиллагаа эрхлэх, нөхөн сэргээлт төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх боломж бүрдэнэ.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүрэн хэрэгжих боломж бүрдэнэ.

## **ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-д заасан асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1	Иргэдийн оролцоог хангах;	Эрүүл аюулгүй орчинд амьдрах, ард түмний мэдэх эрх хэрэгжих;	Мэдэх эрх баталгаажна.

2	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийснээр иргэдийн эрх баталгаажна.	Эрүүл мэндээ хамгаалах боломж бурдэнэ.
---	--------------------------------------	--	--

### ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

#### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	<b>1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг арилгахын тулд авч буй түр, тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	<b>1.2. Оролцоог хангах</b>			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгоходоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бурдүүлсэн эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцсэн
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцнэ
	<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>			

	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	энэ асуудалтай холбогдолгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх			Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх			Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

### ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Үнийн хөөрөгдөл үүсэхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Зах зээлд шинээр орж ирэх аж ахуй нэгжийн тоо нэмэгдэнэ.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Монопол үүсэхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэгэншинэ зардал нэмэгдэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ийм асуудал гарагчийн.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Аж ахуй нэгжийн нэмэгдэнэ.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (ул хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Тийм	Ажлын байр шинээр нэмэгдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Жижиг, дунд үйлдвэр, уул уурхайн баяжуулах боловсруулах салбар хөгжинө.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах		Үгүй	

	зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх			
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

### НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй

	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас барагтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

--- oOo ---

## **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

### **НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа нь санаачлан боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуулийн төсөл төрлөөр боловсруулагдсан хувилбар байв. Иймээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”<sup>1</sup>-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу хийлээ.

### **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг шалгаж тооцно.

<sup>1</sup>Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл тул түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс үнэлэхийг зорьж, Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултуудад хариулах замаар үнэлэхээр сонгосон болно.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсэн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгана.

#### **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дун шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дун шинжилгээ хийв.

Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн заасанд үнэлгээ хийхээр сонгож авлаа.

**“Практикт хэрэгжих боломж”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг шалгаж тооцлоо.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

**ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ  
ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирих шалгах хэрэгслийг дараахь байдлаар авч үзэв.

<b>Д/д</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>	<b>Тохирих шалгах хэрэгсэл</b>
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, боловцоо байгаа эсэхийг шалгах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар <u>ойлгомжтой</u> байдлыг шалгах.
3	Харилцан уялдаа		Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

**“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Үнэлгээ хийхээр сонгож авсан зохицуулалтын хувьд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцэж, хуулийн төслийн зорилтыг хангах боломжтой байна.

**“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:** Хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор иргэдийн мэдэх эрх баталгаажих, эрүүл

мэндээ хамгаалах, хуулийн хүрээнд уул уурхайн үйл ажиллагаа явагдах боломж бүрэн бий болно.

**“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараахь асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.

29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагагүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагагүй.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмөл утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

**“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлгээ аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорьлоо.

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан
2	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн	Шаардлага хангасан.

	нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	
3	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
6	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
7	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
8	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
9	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
10	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
12	хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
13	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.

15	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээ тусгаагүй тул шаардлагагүй.
----	--	--

### **ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийсэн.

Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлүүдийн хувьд хуулийн төслийн үзэл баримтлал болон энэхүү хуулийг төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлагатай нийцэж байгаа нь зорилгод хүрэх, ойлгомтой байх, практикт биелэх боломжтой төдийгүй бусад хууль тогтоомжтой нийцсэн, давхардалгүй, зөрчилгүй томъёологдсон байна.

-----оОо-----

## **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Үндэсний баялагийн сангийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцло

Тусгагдсан зохицуулалттай уялдан зардал үүсгэх болон үүсгэж болзошгүй зүйл, заалтыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судлалаа.

### **ХОЁР. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

Хуулийн төслөөр иргэдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна. Шинээр татвар, зөвшөөрөл, нэмэлт бүртгэлийн асуудал үүсэхгүй тул аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

### **ГУРАВ. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

Хуулийн төслөөр хуулийн этгээдүүдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүдэд нэмэлт зардал үүсгэхгүй гэж үзлээ.

**ДӨРӨВ. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ТӨРД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

Хууль төсөл хэрэгжиж эхэлснээр шинээр татвар, чиг үүрэг төрд шинээр бий болохгүй.

-----oOo-----

Д-Парламент сайт дээр Ашигт Малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байршуулахад.

24.4.4. дэх заалт дээр Лувсан гэх иргэнээс Ашигт малтмал хийхдээ сүм орон нутгийн иргэдийн 50-иас дээш хувиас зөвшөөрөл авах гэсэн заалт оруулж өгхийг хүссэн бөгөөд заалтыг тусгаагүй болно.

**Parliament** БОЛОВСРУУЛЖ БҮЙ ТӨСЛҮҮД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨСЛҮҮД ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ НИЙТИН ӨРГӨДӨЛ ...

Хууль саназылагч нар

1 ДУГЭР ЗҮЙЛ  
2 ДУГААР ЗҮЙЛ  
3 ДУГААР ЗҮЙЛ  
4 ДУГЭР ЗҮЙЛ  
5 ДУГААР ЗҮЙЛ  
6 ДУГААР ЗҮЙЛ

ИХ-ын пышун  
Ширинэнбаньдын АДЬШАА

Боловсруулж бүй Өргөн баригдсан Хэлэлцэх эсэх Ажлын хэсэг Аяхны хэлэлцүүлэг Эцсийн хэлэлцүүлэг Батлах.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 ОНЫ 10-Р САРЫН 16 ВДЭР

УЛААНбаатар

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

✓ Дагах

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.4. "Тухайн талбай нь ёмчлэгч, зээмшигч, ашиглагчаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байх." гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6. "Тухайн тайлбай хамаарах хэсгийг иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж зөвшөөрөл авсан байх, уг зөвшөөрөл сонгон шалгаруулалтын үндэслэл болно." гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7. "Тухайн талбай нь хамаарч буй сүм, дүүргийн иргэдийн хурлаас зөвшөөрөл авсан байх." гэж нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.9. Эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ. гэж нэмсүгэй.

Хууль санасчлагч нар



УИХ-ын гишүүн

Ширнэмбанбаян АДЬШАА

1 ДУГЭРЗҮЙЛ

2 ДУГААР ЗҮЙЛ

3 ДУГААР ЗҮЙЛ

4 ДУГЭРЗҮЙЛ

5 ДУГААР ЗҮЙЛ

6 ДУГААР ЗҮЙЛ

Боловсруулж бүй Өргөн баригдсан Хэлэлцэх эсэх Ажлын хэсэг Аихны хэлэлцүүлэг Эцсийн хэлэлцүүлэг Батлах.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 ОНЫ 10-Р САРЫН 16 Ө.С.ВР

УЛААНБААТАР

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



✓ Дагах

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.4. "тухайн талбай нь өмчлөгч, ззэмшигч, ашиглагчаас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байх." гэж нэмсүгэй.

12 97 01

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6. "Тухайн тайлбай хамаарах хэсгийг иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж зөвшөөрөл авсан байх, уг зөвшөөрөл сонгон шалгаруулалтын үндэслэл болно." гэж нэмсүгэй.

12 95 01

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7. "Тухайн талбай нь хамаарч буй сүм, дүүргийн иргэдийн хурлаас зөвшөөрөл авсан байх." гэж нэмсүгэй.

12 95 01

4 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.9. Эрүүл мэндэд нелөөлөх байдлын үнэлгээ. гэж нэмсүгэй.

12 95 01